

Азийн сангийн зөвлөх, Хонконгийн авлигын эсрэг бие даасан хорооны дэд комиссар асан, ноён Тони Квокийн илтгэл

Авлигатай тэмцсэн олон улсын тэргүүн туршлага

Миний бие энэхүү нэр хүндтэй бага хуралд орооцож байгаагаад туйлын их баяртай байна. Юуны өмнө Монгол Улсад намайг гуав дахь удаагаа ирэхийг урьсан Азийн сан болон Монгол Улсын Авлигатай тэмцэх газар /АТГ/-т талархаж буйгаа илэрхийлье. Миний гол зорилго бол АТГ-т авлигатай тэмцэх үйл хэргээ амжилттай эхлэхэд нь туслах явдал юм. Тийм ч учраас миний бие энэхүү бага хурлыг цагаа олсон бөгөөд дээрх зорилгод хувь нэмэр болохуйц арга хэмжээ болно гэдэгт итгэж байна.

Би Хонконгийн Авлигын эсрэг бие даасан хороо /АЭБДХ/-нд 1975 онд байгуулагдсаных нь дараахнаас эхлээд нийт 27 жил ажилласан бөгөөд Хонконгийг хамгийн их авлигад автсан орноос хамгийн авлигагүй цэвэр улс болгон хувиргах амжилттай дайнд оролцсон билээ. Миний бие тэтгэвэрт гарснаасаа хойш авлигын эсрэг зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, илтгэл тавих зорилгоор 17 улсад уригдсан ажилласны дийлэнх нь Азийн орнууд юм. Би мөн Хонконгийн их сургуулиас зохион явуулдаг олон улсын авлигын эсрэг сургалтын захирлаар ажилладаг бөгөөд уг сургалтад одоогийн байдлаар 21 орны авлигатай тэмцэх албаны хүмүүс хамрагдаад байгаагийн ихэнх хувь нь Азийн орнуудаас ирсэн байдаг. Тийм ч учраас би өөрийгөө авлигатай хэрхэн амжилттай тэмцэх талаар ярих ёстой хүний нэг гэж бодож байна.

Миний ажигласнаар авлигатай хийх тэмцэл амжилтад хүрч чадах эсэхийг тодорхойлдог гол хүчин зүйл бол дээд шатанд улс төрийн зориг эрмэлзэл байна уу үгүй юу гэдэг асуудал юм. Мэдээж бүх Засгийн газар бидэнд улс төрийн зориг эрмэлзэл байгаа гэгцгээдэг. Гэхдээ бид тэрхүү зориг эрмэлзэл нь жинхэнэ эсэхийг хэрхэн мэдэх вэ? Үүнийг мэдэхийн тулд доорх хэмжүүрийг ашиглаж болох юм:

1. Юуны түрүүнд Засгийн газар авлигатай тэмцэх төсөвт хэдий хэр хөрөнгө зарцуулдаг вэ? Хонконгт бид Засгийн газрын төсвийн 0.3-0.4 хувийг АЭБДХ-нд зарцуулдаг бөгөөд бид үүнийг нэлээд тохиромжтой хэмжээ гэж үздэг. Миний бодлоор ялангуяа авлига тулгамдсан асуудлын нэг болоод байгаа газар төсвийнхөө иймхэн бага хувийг авлигатай тэмцэх ажилд зориулан гаргаж чадахгүй гэж хэлэх ямар ч Засгийн газар байхгүй байх. Хэдий тийм боловч авлигад идэгдсэн олон оронд нийт төсвийнхөө 0.01 хувиас бага хувийг авлигын эсрэг тэмцэлд зарцуулдаг бөгөөд энэ нь чухамдаа авлигын эсрэг тэмцэх амжилт олохгүй байдгийн гол шалтгаан гэдгийг өөрийн туршлагаас мэднэ. Харамсалтай нь Монгол Улсын АТГ үүнтэй адил нөхцөлд байна. Тэдэнд хуваарилсан төсөв миний бодлоор дэндүү бага, хүрэлцээгүй байна. Тэдний 2007 оны жилийн төсөв Засгийн газрын нийт төсвийн дөнгөж 0.01 хувийг эзэлж байна. Хэрэв Монгол Улсын Засгийн газар өөрийн улс төрийн хүсэл эрмэлзлийг харуулахыг хүсч байгаа бол АТГ-ын төсвийг илүү хангалттай төвшинд хүргэж нэмэгдүүлэх учиртай.
2. Хоёрдугаарт, АТГ-т авлигын асуудлыг мөрдөн шалгахад хууль эрх зүйн зохих дэмжлэг бий юу? Авлига нь нууцаар үргэлжилдэг шинж чанарынхаа улмаас мөрдөн шалгахад хамгийн их бэрхшээлтэй тулгардаг гэмт хэрэг бөгөөд АТГ үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахын тулд хүчтэй эрх

мэдэлтэй байх шаардлагатай. АТГ-аас албан тушаалаа хувийн ашиг хонжоо олох зорилгоор урвуулан ашиглах, хууль бусаар баяжих, хөрөнгө, орлогын мэдүүлгээ хуурамчаар гаргаж өгөх, мөнгө угаах зэрэг гэмт хэргийн талаар Эрүүгийн хуульд оруулах хэд хэдэн нэмэлт, өөрчлөлтийг санал болгосон. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь амин чухал бөгөөд олон улсын туршлага болоз НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид нийцсэн юм. УИХ-ын гишүүд эдгээр нэмэлт, өөрчлөлтийг цаг алдалгүй баталж, улс төрийн зориг эрмэлзлээ нотлон харуулах учиртай.

3. Гуравдугаарт, АТГ өөрийн үйл ажиллагааг улс төрийн аливаа хөндлөнгийн оролцоогүй явуулж чадах эсэх.

4. Дөрөвдүгээрт, Засгийн газар авлигыг үл тэвчих бодлого баримталж буй эсэх. Хэрэв нийгэмд давхар хэм хэмжээ үйлчилж, жижиг авлигыг хүлцэж, хувийн хэвшлийн авлигыг тэвчин өнгөрүүлээд байх юм бол нийгэм жинхэнэ ёсоор цэвэр болох боломжгүй юм.

Улс төрийн зориг эрмэлзлээс гадна авлигатай тэмцэх талаар хоёр алдаатай ойлголтын тухай ярихыг хүсч байна. Нэгдүгээрт, авлигатай тэмцэх цорын ганц арга зам гэж байхгүй гэдгийг ойлгох ёстой. Энэ асуудалд цогцоор нь хандах учиртай. Олон улсын хэмжээнд өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн төдийгүй НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид тусгалаа олсон Хонгконгийн загвар бол авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, боловсрол олгох гэсэн гурван тулгуураас бүрддэг. АТГ ч энэхүү стратегийг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байгаад миний бие сэтгэл хангалуун байна. Хоёрдугаарт, авлигатай тэмцэхдээ зөвхөн ганц байгууллагад найдаж болохгүй гэдгийг ойлгох хэрэгтэй. АТГ-аас гадна хүчин чармайлтаа хамтатгах нийгмийн бүх түншүүдийн эвсэл байх нь зүйтэй. Уг түншлэлд Засгийн газрын бүх яам, шүүх, парламент, хувийн хэвшил, мэргэжлийн байгууллагууд, иргэний нийгэм, хандивлагчид, хэвлэл мэдээлэл болон олон нийт багтвал зохино.

Миний бие Филиппин болон Нигерийн Ерөнхийлөгч нарт өөрсдийн яам, Тамгын газрын сайд, дарга нарт зориулсан авлигын эсрэг семинар зохион байгуулахад нь туслалцаа үзүүлж байсан юм. Эхэндээ эдгээр сайд, дарга нар авлигатай тэмцэх явдал тэдний хамгийн чухал үүрэг гэж үзэхүй байсан нь гайхалтай. Гэхдээ сонирхолтой нь уг семинарын үр дүнд тэд “гэрээ” өөрсдөө цэвэрлэх үүрэгтэй гэдгээ илүү сайн ойлгосон бөгөөд тэдний өөрсдийн хийж чадах ба хийх ёстой маш олон зүйл байгаа гэдэгтэй санал нэгдсэн билээ. Эдгээр семинар Засгийн газрын яамдын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг зөвшилцөн баталснаар өндөрлөсөн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулж буй энэхүү бага хурал хуралдааныхаа төгсгөлд мөн тийм үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан гаргах байх гэдэгт итгэж байна. Энд би яам бүрийн дагаж мөрдөх учиртай 12 зүйл бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг санал болгож байна:

1. Өөрийн яаманд Авлигын эсрэг удирдах хороо байгуулах
2. Дүрэм журам, тогтолцоог эргэн харж, илүү тод, хариуцлагатай болгох
3. Ёс зүйн тусгай дүрмийг бий болгож, түүндээ бэлэг сэлт авах асуудлыг хэрхэн зохицуулах талаар тусгах
4. Ашиг сонирхлын зөрчлийг мэдээлдэг тогтолцоог бий болгох
5. Нээлттэй, шударгаар ажилд авах, албан тушаал дэвшүүлэх тогтолцоог хөхиүлэн дэмжих, ингэхдээ ажилтны шударга байдлыг шалгаж байх

6. Ажилтнууддаа ёс зүй, авлигаас урьдчилан сэргийлэх талаар сургалт явуулж байх
 7. Үлгэрлэн манлайлах
 8. Авлигыг үл тэвчих бодлогыг тунхаглах
 9. Ажилтнуудын дотоод хяналт, аудитын нэгжийг бий болгох
 10. Олон нийтийн болон байгууллагын дотоодын нууцаар гомдол гаргах сувгийг бий болгох, бэхжүүлэх, гомдол хүлээж авах утас ажиллуулах
 11. АТГ-т авлигын хэрэг тохиолдлыг цаг алдалгүй мэдэгдэх, мөрдөн шалгах ажлаар АТГ-тай бүх талаар хамтран ажиллах
 12. Олон нийтийн шударга ёсны кампанит ажил, төсөл хэрэгжүүлэхэд АТГ, хэвлэл, мэдээлэл, иргэний нийгмийн болон олон улсын хандивлагч байгууллагуудтай хамтран ажиллах
- Өнөөдөр Монгол Улс авлигын эсрэг тэмцэх замын бэлчир дээр ирээд байна гэдгийг онцлон хэлэхийг хүсч байна. АТГ байгуулагдсаныг олон нийт өргөнөөр таашаан хүлээн авах учиртай бөгөөд авлигатай амжилттай тэмцэхэд шаардагдах дэмжлэгийг олон нийтээс авахад бэрхшээл учрах ёсгүй. Хэдий тийм боловч хэрэв АТГ олон нийтийн хүсэн хүлээж байсан үр дүнг авчирч чадахгүй бол ард олны тэрхүү дэмжлэг тун удалгүй алга болж, оронд нь үл итгэх уур амьсгал, сэтгэл ханамжгүй байдал бий болно. Тэр цагт олон нийтийн дэмжлэгийг эргүүлж олоход туйлаас хэцүү байх болно. Тийм учраас миний бие та бүгдэд, ялангуяа олон улсын хандивлагч байгууллагуудад АТГ-т бололцоотой бүхнээр дэмжлэг үзүүлэх энэхүү алтан боломжийг алдахгүй байж, АТГ-ыг үйл ажиллагаагаа амжилттай эхлүүлэх боломжоор хангахыг уриалж байна.
- Анхаарал хандуулсанд баярлалаа.